



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ



RioTinto

УУРХАЙН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГ

СУДАЛГААНЫ
ТЭТГЭЛГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДАМЖ

2021 он

Судалгааны тэтгэлэгт хөтөлбөр

СУДАЛГААНЫ ТЭТГЭЛГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

Оюу толгой ХХК, Рио Тинто Монгол болон ШУТИС хоорондын “Геотехник, уул уурхайн мэргэжилтний ур чадварыг сайжруулах төсөл” –ийн хүрээнд хэрэгжүүлэх “Судалгааны тэтгэлэг” олгоход энэхүү удирдамжийг дагаж мөрдөнө.

*“Геотехник, уул уурхайн мэргэжилтний ур чадварыг сайжруулах” төслийн ажлын хэсгээс
боловсруулж батлав.*

НЭГ. УДИРДАМЖИЙН ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 **Судалгааны тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх үндэслэл:** Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болох уул уурхайн салбарт хэрэгцээтэй байгаа инженерүүдийг бэлтгэх, геологи, уул уурхайн салбарын судалгаа шинжилгээг хөгжүүлэх зорилгоор 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн “Оюу Толгой” ХХК болон ШУТИС-ийн ГУУС-ийн хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн “Оюу толгой” ХХК, ШУТИС болон “Рио Тинто Монгол” ХХК-ний хооронд байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан бөгөөд уг хамтын ажиллагааны хүрээнд ‘Геотехник, уул уурхайн мэргэжилтний ур чадварыг сайжруулах төсөл’-ийг 2021-2026 онд хэрэгжүүлэхээр эхлүүлээд байна. Төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь уул уурхайн үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлыг шийдэхэд их сургууль аж үйлдвэрийн хамтарсан судалгааг хөгжүүлэхээр Судалгааны Тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.2 **Зорилго:** Уурхайн үйлдвэрлэлийн бүтээмж, тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг дээшлүүлэхэд Оюу Толгой ХХК, “Рио Тинто Монгол” ХХК болон ШУТИС хамтарч гүний уурхайд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн судалгааны ажлыг дэмжин шинэ мэдлэгийг бий болгох үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 1.2.1 Оюу толгой уурхайд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх;
 - 1.2.2 ШУТИС-ийн судалгаа хөгжүүлэлтэд зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлэх, үр дүнтэй судалгаа хийх чадавхийг бүрдүүлэх;
 - 1.2.3 ШУТИС, Оюу толгой ХХК, “Рио Тинто Монгол” ХХК болон гадаадын их, дээд сургууль, бусад оролцогч талуудын эрдэмтэн судлаачдын судалгаа хөгжүүлэлтийн хамтын ажиллагааг дэмжих;
 - 1.2.4 Монгол улсын уул уурхайн салбарт хувь нэмэр оруулах салбар дундын судалгааг хөгжүүлэх.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Оюу толгой ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК -ийн инженер техникийн ажилтнууд, ШУТИС-ийн нийт багш судлаач, ажилтан, ахисан түвшний оюутнууд болон бусад сонирхогч талуудад хамаарна.
- 2.2 Уурхайн тэтгэлэгт хөтөлбөр /цаашид “СТХ” гэх/-т хамрагдах төслийн удирдагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны профессор, багш судлаач байх ба энэхүү удирдамжийн 2.1-т заасан талуудаас багаа бүрдүүлэн төсөл мэдүүлнэ.

ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- Энэ удирдамжид хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
- 3.1 **Судалгааны тэтгэлэг:** Судалгааны төслийг санхүүжүүлэх зориулалттай Оюутолгой ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК -аас олгох хөрөнгийг;
 - 3.2 **Удирдах хороо:** Тэтгэлэгт хөтөлбөрийг ерөнхий удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Оюутолгой ХХК, Рио Тинто ХК, ШУТИС-ийн төлөөллөөс бүрдсэн удирдах багийг;
 - 3.3 **Үнэлгээний комисс:** Тэтгэлэгт хөтөлбөрт ирүүлсэн судалгааны төслийн саналуудад тодорхой шалгуурын дагуу үнэлгээ хийж чадах хөндлөнгийн экспертүүдээс бүрдсэн, тэтгэлэг олгох эсэх шийдвэрийг гаргахад нь Удирдах хороонд зөвлөх экспертийн багийг;
 - 3.4 **СТХ-ийн Нарийн бичиг:** Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохион байгуулж, хариуцан ажиллах мэргэжилтнийг;

- 3.5 **Судалгааны тэтгэлгийн төсөв:** Тухайн онд батлагдсан санхүүжилтийн дүнг;
- 3.6 **Судалгааны төсөл:** Багш судлаачдын оролцон гүйцэтгэх тодорхой үр дүн, хүлээлт бүхий даалгаварт судалгааны ажлыг.

ДӨРӨВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1 **Хөтөлбөрийн удирдлага, менежмент:** “ШУТИС-д геотехник, уул уурхайн мэргэжилтний ур чадварыг сайжруулах” төслийн Удирдах Хороо нь уг тэтгэлэгт хөтөлбөрийг ерөнхий удирдлагаар хангаж, Үнэлгээний Комисс судалгааны төслүүдэд үнэлгээ хийж, тэтгэлэгт хөтөлбөрийн бичиг хэргийн ажлыг Нарийн бичиг тус тус хариуцан ажиллана.
- 4.2 **Удирдах хороо нь** Оюу Толгой, Рио Тинто Монгол ХХК болон ШУТИС-ийн дунд уг тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагыг хариуцан ажиллаж, судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн стратегийг боловсруулах, жилийн төсвийг батлах, Үнэлгээний комиссын гишүүдийг томилох, Үнэлгээний комиссын судалгааны төслийн саналд өгсөн тайлан болон мониторингийн тайланг батлах үүргийг гүйцэтгэнэ.
- 4.3 **Үнэлгээний комисс нь** судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт ирүүлсэн төслийн саналуудад үнэлгээ хийж Удирдах хороогоор шийдүүлэх гол үүргийг гүйцэтгэнэ. Комисс нь Оюу Толгой болон Рио Тинто Монгол ХХК-ийн ахлах инженер болон сургалтын менежерийг оролцуулсан 3 төлөөлөл болон ШУТИС-ээс бусад их, дээд сургуулийн уул уурхайн чиглэлийн профессор багшийн төлөөлөл бүхий 7-9 гишүүнтэй байна. Үнэлгээний комиссын гишүүний шаардлагыг хангасан боломжит мэргэжилтнийг ШУТИС болон Рио Тинто Монгол, Оюу толгойгоос Төслийн удирдах хороонд санал болгосны үндсэн дээр Удирдах хорооноос гишүүдийг томилоно.
- 4.4 **Нарийн бичиг нь** тэтгэлэгт хөтөлбөрийн зохион байгуулалт, бичиг хэргийн ажлыг хариуцах бөгөөд ШУТИС-ээс томилогдсон мэргэжилтэн байна. Тэтгэлэгт хөтөлбөрийг зарлах, сонирхогчдод мэдээлэл өгөх, төслийн саналуудыг шалгаж хүлээж авах, Төслийн удирдах хороо болон Үнэлгээний комиссын өмнөөс Гол судлаачтай харилцах, Удирдах хороо болон Комиссын хурлыг зохион байгуулах, судалгааны явцын тайлан болон үр дүнгийн тайланг үнэлж батлахад туслах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

ТАВ. ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

- 5.1 Судалгааны тэтгэлгийг 2021-2025 онуудад хэрэгжүүлэх бөгөөд 2021-2022 онд жижиг судалгааны тэтгэлгийг эхлэл байдлаар зарлаж, 2022-2025 онуудад үндсэн судалгааны тэтгэлгийг зарлаж, уул уурхайд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхүйц судалгааны төслүүдийг сонгон шалгаруулж, санхүүжүүлнэ.
- 5.2 **Төсөл нь дараах үндсэн чиглэлүүдийг хамарсан байна. Үүнд:**
- 5.2.1 Оюу Толгой гүний уурхайн ахлах инженерийн багаас боловсруулсан агуйлан олборлох үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдэх тэргүүлэх чиглэлийн судалгаанд хамаарах төсөл. Үүнд: /2021-2022 он/
- Геологийн структурын төрлүүдийн орон зайн 3D чиг баримжааг зөв тодорхойлж тэдгээртэй холбоотой гадаргуугийн шинж чанарыг тодорхойлох
 - Агуйлан олборлолт гадаргуутай огтлолцох үед гадаргуугийн суултанд нөлөөлөх нөлөөг судлах;
 - Чулуулгийн массыг бэхжүүлэхэд давирхайлаг цавуу шахах;
 - Чулуулгийн массыг урьдчилан тохируулах - газар хөдлөлтийн идэвхтэй чулуулаг дахь чулуулгийн массыг стрессээс гаргахын тулд өрөмдлөг, тэсэлгээний техник ашиглах судалгаа.
- 5.2.2 Улс орны хөгжлийн бодлого, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Оюу толгой, Рио Тинто Монгол ХХК болон ШУТИС-ийн хөгжилд хувь нэмэр оруулах үр дүн гарахаар төсөл;
- 5.2.3 Оюу толгой ХХК, ШУТИС болон гадаад, дотоодын их дээд сургууль, ЭШБ-уудын багш

судлаач нарын хамтарсан баг салбар хоорондын интеграцийг бүрдүүлэх, салбар дундын асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий төсөл.

5.3 Судалгааны төсөлд тавигдах шаардлага:

- Судалгаагаар шийдвэрлэх асуудлыг маш тодорхой тавьсан, судалгааны ач холбогдлыг тодорхойлсон, тохирох судалгааны арга замыг сонгосон байх;
- Судалгааны үр дүн нь мэдлэгийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдэх бодит үр нөлөө үзүүлэхүйц судалгааны бүтээл байх;
- Төсөл хэрэгжүүлснээр патент, ашигтай загвар авах боломжтой байх;
- Үр дүнг шилжүүлэх, борлуулах, ашиглахыг зөвшөөрсөн байх;
- Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг бүрдүүлсэн байх (ШУТИС-ийн ахисан түвшний сургалтанд суралцаж байгаа /1-2 хүн/ магистрант, докторантыг хамруулах);
- Төслийн үндэслэл, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх хугацаа, техник технологийн шинжилгээ, санхүүжилтийн зарцуулалт, үр өгөөжийн талаар танилцуулга бүхий төсөл бичсэн байх;
- Төслөөр хүсэж буй санхүүжилтийн хэмжээ **35.0** сая хүртэлх төгрөг байна.
- Судалгааны төслийг хэрэгжүүлэх хугацаа 12 сараас хэтрэхгүй байна.

5.4 **Төсөл дэвшүүлэх баг:** Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт төсөл дэвшүүлэх төслийн удирдагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны багш судлаач байх бөгөөд төслийн багийн гишүүдэд бусад гадаад, дотоодын их дээд сургуулийн уул уурхайн чиглэлийн багш нар, ахисан түвшний оюутан болон зөвлөх инженер, Оюу Толгой, Рио Тинто Монгол ХХК-ийн инженер техникийн ажилтнууд хамрагдаж төслийн санал мэдүүлэх боломжтой.

5.5 Судлаачидад тавигдах шаардлага:

Төслийн удирдагч

- Төслийн удирдагч нь ШУТИС-ийн үндсэн орон тоонд ажилладаг, доктор (Ph.D) буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой Монгол улсын иргэн байна.
- Төслийн удирдагч нь үндсэн ажилтны хөдөлмөрийн гэрээтэй байх бөгөөд хөдөлмөрийн гэрээний хугацаа судалгааны төслийн хугацаанаас хойш байна.
- Төслийн удирдагч нь судалгааны багийн нэрийн өмнөөс санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, төслийг амжилттай хэрэгжүүлэх үүргийг хүлээж төслийн эрдэм шинжилгээний болон менежментийг удирдан чиглүүлэх үүрэгтэй.
- Төслийн удирдагч нь судалгааны төслийн багийг төлөөлж төслийн бүх асуудлаар санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагатай харилцана. Харин хамтарсан судлаачдын хамтаар судалгааны төслийн үр дүн, тайланг хариуцна.

Хамтарсан судлаач

- Хамтарсан судлаач нь гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллагад үндсэн ажилтны гэрээтэй ажилладаг доктор (Ph.D) буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой иргэн байна.
- Хамтарсан судлаач нь гадаадын их сургуулийн багш бол тухайн их сургууль нь ШУТИС-тай хамтын ажиллагааны гэрээ хийсэн байна.
- Хамтарсан судлаач нь төслийн эрдэм шинжилгээний болон менежментийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Хамтарсан судлаач нь судалгааны төслийн багийг төлөөлж санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагатай харилцахгүй, гэхдээ төслийн удирдагчийн хамтаар судалгааны төслийн үр дүн, тайланг хариуцна.

Туслах судлаач

- Туслах судлаач нь судалгааны саналыг боловсруулахад тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж, хэрвээ судалгааны тэтгэлэг авбал туслах судлаачаар авч ажиллуулахад өөрийн ажлын ихэнх цагийг зарцуулан (гэрээний цагийн 50%-ийг эзлэх) ажиллахаар тохирсон судлаач байна. Судалгааны саналд туслах судлаачийн цалинг төслийн хугацаанд хэд байхыг мөн

туслах судлаачийн хийх ажлыг тодорхойлсон байна. Туслах судлаач нь судалгааны төслийн хугацаанд судалгааны тэтгэлгийн санхүүжилтээс цалинжина. Пост доктор, магистр, докторын оюутан болон их сургуулийн багш бус залуу судлаач нар туслах судлаачаар ажиллаж болно.

5.6 Төсөл мэдүүлэхэд бүрдүүлэх материал:

Судалгааны төсөл санаачлагч баг нь доорх материалыг бүрдүүлэн ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газарт и-мэйлээр [/research@must.edu.mn/](mailto:research@must.edu.mn) хүсэлтээ хүргүүлнэ.

- Харьяалах бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлагын гарын үсэг бүхий төслийг дэмжсэн албан бичиг;
- Судалгааны төсөл боловсруулах, дэвшүүлэх заавар /Хавсралт №1/-ын дагуу бөглөж баталгаажуулсан ТӨСӨЛ
- Баталгаажуулсан зардлын задаргааны маягт – Хавсралт №5
- Төсөлд оролцож буй судлаачдын CV /А4-ийн нэг нүүрэнд багтсан байх, судлаач тус бүр дээр/

5.7 Төслийн материал ирүүлэх, шалгаруулах хугацаа:

Төслийн материалыг 2021 оны 9 дүгээр сарын 15-30-ны өдрийн хооронд хүлээн авна. Ирүүлсэн судалгааны төслүүдэд үнэлгээ хийж, 12 сард сонгон шалгаруулна.

5.8 Судалгааны төслийг зарлах, шалгаруулах үйл явц:

Оюу Толгой ХХК-ийн нэрэмжит Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн судалгааны төсөл шалгаруулах үйл явц 8 үе шаттайгаар нээлттэй хэлэлцэж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Сонгон шалгаруулалтын дэлгэрэнгүй үйл явцыг Хавсралт № 4-өөс үзнэ үү.

ЗУРГАА. ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

6.1 2021-2022 онуудад санхүүжүүлэх жижиг судалгааны төслийн нийт тэтгэлгийн хэмжээ 140.0 сая төгрөг байна.

6.2 Нэг төсөлд олгох тэтгэлгийн хэмжээ 35.0 сая төгрөг хүртэлх байна.

6.3 Судалгааны тэтгэлгийн зориулалт, зарцуулалт

Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтийг зөвхөн судалгаа хийхтэй холбоотой зардалд зарцуулна. Судалгааны зардалд дараах зардлууд багтаж болох ч зөвхөн эдгээр зардлаар хязгаарлагдахгүй.

6.3.1 Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт тэнцсэн судалгааны төслийг гүйцэтгэх судлаачдыг ажиллуулах зардал;

6.3.2 Лабораторийн туршилт хийхтэй холбоотой зардлууд;

6.3.3 Судалгаатай холбоотой технологийн лиценз худалдан авах

6.3.4 Магистр, докторын оюутны стипенд, ажлын хөлс

6.3.5 Орон нутагт судалгаа хийхэд гарах замын зардал

6.3.6 Судалгаатай холбоотой илтгэл тавих эрдэм шинжилгээний хуралд оролцох

6.3.7 Гадаадын их дээд сургуультай хамтарсан төслийн гадаад судлаачийн замын зардал

6.3.8 Судалгааны ажлын үр дүнг импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх болон оюуны өмчийн хамгаалалт хийлгэх зардал

6.3.9 ШУТИС-ийн дэд бүтэц, материаллаг баазыг ашигласны шимтгэл хураамж

6.4 ШУТИС-ийн нэр хүнд, хүний нөөц, оюуны өмч, биет бус хөрөнгө, ажлын байр, лабораторийн материаллаг бааз болон урьд хуримтлагдсан мэдээллийн баазыг ашигласан зардлын хэмжээ /цаашид “шимтгэл” гэх/ төслийн төсөвт өртгийн 10 хувь байхаар тооцож төслийг мэдүүлнэ.

6.5 Төслийн удирдагч болон гүйцэтгэгч нар төсөл батлагдахаас өмнө төслийн эрдэм шинжилгээний зардлын задаргааны маягт /Зардлын маягт: Хавсралт 5/ дээр харьяа сургуулийн захирал, ахлах нягтлан бодогчоор хянуулж гарын үсэг зуруулсан байна.

6.6 Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах судалгааны дараах төрлийн зардлын дээд хязгаарыг доорх хүснэгтийн дагуу тогтооно.

№	Зардлын ангилал	Нийт төсөвт эзлэх дээд хязгаар /хувь/
1	Төслийн багийн Монгол судлаачдын цалин хөлс, НДШ	25%
2	Магистр, докторын оюутны стипенд, ажлын хөлс	10%
3	Лабораторийн туршилт, судалгаа шинжилгээний зардал	25%
4	Гадны байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр	10%
5	Гадаад, дотоод томилолтын зардал	15%
6	Судалгааны үр дүнг хянан магадлагаа өндөртэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх	5%
7	Их сургуулийн лаборатори, судалгаа-туршилтын бааз, багаж, төхөөрөмж, бичиг хэрэг, захиргааны үйлчилгээг ашигласны шимтгэл	10%

Жич: Судалгааны онцлогоос хамаарч төсвийн хязгаарыг гэрээнд тусгаж зохицуулж болно.

- 6.7 Судалгааны төслийг шалгаруулахад Төслийн удирдах хороо, Үнэлгээний комисс, Нарийн бичиг гэсэн бүтэцтэй байна. Төслүүдийн үнэлгээг харгалзан сонгон шалгаруулж санхүүжилт олгох гэрээ байгуулах эцсийн шийдвэрийг удирдах хороо гаргана.
- 6.8 Шалгарсан төслүүдэд олгох санхүүжилтийг Оюу толгой ХХК-аас төслийн удирдагчийн дансанд шилжүүлнэ. Харин их сургуулийн дэд бүтэц, материаллаг баазыг ашигласны шимтгэл хураамжийг ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газрын /цаашид ЭШИГ гэнэ/ дансанд төвлөрүүлнэ. ЭШИГ нь судалгааны төслүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
- 6.9 **СТХ -ийн санхүүжилт олгохыг мэдэгдэх**
СТХ-т тэнцсэн судалгааны төсөлд санхүүжилтийн талаар мэдэгдэхдээ санхүүжилтийн хэмжээ, санхүүжилттэй холбоотой тусгай нөхцөл байвал оруулж, төслийн эхлэх болон дуусах өдөр, батлагдсан төсвийн задаргаа, төсөлд бага зэрэг засвар хийх шаардлагатай гэж үзвэл зөвлөмжийг багтаасан мэдэгдэлийг и-мэйлээр явуулна.
- 6.10 **Төслийн эхлэх, дуусах хугацаа**
- Төслийн эхлэх өдөр нь сарын 1 эсвэл 15-нд байна. Санхүүжилт олгох мэдэгдэлтэй хамгийн ойрхон болох 1 эсвэл 15-нд төслийн эхлэх өдрийг товлон.
 - Дуусах өдрийг санхүүжилтийн мэдэгдэлд тодорхой заасан байна. Эцсийн өдрөөс хойш зардал тооцоо хийхгүй.
- 6.11 **Төслийн үргэлжлэх хугацааны өөрчлөлт, сунгалтыг баталгаажуулах**
- а. Эхлэх өдөр**
Санхүүжилт олгох шийдвэр гармагц, эхлэх өдрийг өөрчлөх боломжгүй болно.
- б. Дуусах өдөр**
Дуусах өдөр дараах тохиолдлуудаад өөрчлөгдөж болно. Төслийг үргэлжлүүлэх нэмэлт санхүүжилт авах хүсэлт нь батлагдсан, эсвэл зардал гаргахгүйгээр сунгах хүсэлт нь батлагдсан тохиолдлууд. Төслийн Удирдах Хорооноос өөрчлөлтийг батална.
- в. Зардал гаргахгүй сунгалт**
Төслийн ажлыг бүрэн гүйцэд дуусгавар болгож, хангалттай түвшинд тайланг бичихэд сунгалт шаардлагатай бол, нэг удаа 6 сар хүртэлх хугацаагаар төслийн дуусах өдрийг сунгаж болно. Энэ сунгалт нь төслийн зарцуулагдаагүй санхүүжилтийг дуусгах зорилгоор хийгдэж буй сунгалт биш учраас сунгалтын хугацаанд аливаа санхүүгийн гүйлгээ хийгдэхгүй. Төслийн ахлагч сунгалт ямар шалтгаанаар шаардлагатай болсныг албан бичгээр төслийн дуусах өдрөөс 30 хоногоос багагүй хугацааны өмнө СТХ хариуцсан Нарийн бичигт бичгээр хүсэлт гаргана.
- д. СТХ -өөс зөвшөөрөл авсан сунгалт**
Төслийн ажил хүндэтгэх шалтгаанаар хойшилж, төслийн үр дүнг хангалттай биелүүлэхэд хугацаа сунгах зайлшгүй шаардлага гарвал, учир шалтгааныг СТХ-т наад зах нь 45 хоногийн өмнө мэдэгдэж, төслийг сунгах хүсэлтийг и-мэйлээр илгээж, албан ёсны зөвшөөрөл авч төслийн дуусах хугацааг 6 сар хүртэлх хугацаагаар сунгуулж болно. Төслийн зарцуулагдаж амжаагүй байгаа үлдсэн санхүүжилтийг зарцуулах нь сунгалтын үндэслэл болохгүй.

ДОЛОО. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ

7.1 Төслийн гэрээ байгуулах, баталгаажуулах

- Тэтгэлэгт хөтөлбөрийн төслийн гэрээг санхүүжүүлэгч Оюу толгой болон Рио Тинто Монгол ХХК, хэрэгжүүлэгч ШУТИС, гүйцэтгэгч Төслийн удирдагч нар гурвалсан гэрээ байгуулна. ШУТИС-ийн нэрийн өмнөөс (Бүрэлдэхүүн сургууль, Хүрээлэн хамрагдана) байгуулах төслийн гэрээнд зөвхөн Их сургуулийн Захирал (Ректор) болон ЭШИХ эрхэлсэн дэд захирал гарын үсэг зурж баталгаажуулна.
- Төсөл хэрэгжүүлэх багийн ахлагч нь төслийн гэрээг батлуулахдаа их сургуулийн төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч нараар хянуулсны дараа эрх бүхий тушаалтнаар гэрээг батлуулна.

7.2 Төслийг ШУТИС-ийн эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн системд бүртгэх

- Төслийн удирдагч нь тухайн төсөл дээр ажиллах гүйцэтгэгч багийг бүрдүүлж, төслийн ажлын даалгавар, түүнийг хийж гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөө, төслийн санхүүжилтийн зардлын хуваарилалтыг ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлд албан ёсоор танилцуулж арга зүйг батлуулна.
- Тухайн бүрэлдэхүүн сургууль хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр баталгаажсан шинээр эхэлж буй төслийн мэдээллийг Эрдэмтэн нарийн бичгийн дарга “Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн систем” дэх төслийн мэдээллийн баазад бүртгэж оруулна.

7.3 Төслийг хэрэгжүүлэх, хяналт тавих

- Төслийн гэрээнд заасан үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийн графикт заасны дагуу хэрэгжилт, явцын үйл ажиллагаа, үр дүнг хэрэгжүүлэгч сургууль, санхүүжүүлэгч Оюу толгой, Рио Тинто Монгол ХХК-д тайлагнаж, холбогдох мэргэжилтнүүд хянаж баталгаажуулсаны үндсэн дээр дараагийн санхүүжилтийг олгоно.
- Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн нягтлан бодогч нь төслийн санхүүгийн бүртгэл, тайлан тооцоог зохих журмын дагуу гаргах үүргийг хүлээнэ.
- ШУТИС-ийн нэрийн өмнөөс төсөл хэрэгжүүлэхэд их сургуулийн болон тухайн нэгжийн ажлын өрөө, сургалтын анги танхим, судалгааны лабораторийн багаж, тоног төхөөрөмж, компьютер болон бусад техник хэрэгслийг ашиглаж болно.
- Төслийн арга зүйн түвшин, хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал, санхүүгийн үйл ажиллагаанд бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хагас жил тутам хэлэлцүүлж, хяналт тавина.
- Төслийн явцын тайланг 6 сар тутамд хийх бөгөөд тайлангийн хугацаанд хийсэн ажлыг санхүүжилтийн зарцуулалтын хамт тайлагнана. Тайланг одоогийн санхүүжүүлсэн төсвийг дуусахаас 45 хоногоос багагүй хугацааны өмнө илгээж, дараагийн санхүүжилтийг цаг хугацаанд нь авах нөхцлийг бүрдүүлнэ. Уг тайланг СТХ-ийн нарийн бичигт албан и-мэйлээр явуулах бөгөөд СТХ-өөс уг тайланг хянан үзэж, дараагийн санхүүжилт олгох эсэхийг Төслийн удирдах хорооноос батална. Одоогийн санхүүжилтийн хамрах хугацаа дуусахаас 45 хоногоос доош хугацааны өмнө явуулсан тайланг хоцорсонд тооцож, төслийн дараагийн санхүүжилт хойшлогдоно.
- Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга нар төслүүдийн хэрэгжилтийн талаар эрдмийн зөвлөлийн дүгнэлт, тайланг нэгтгэж хагас жил (12, 6 сар) тутам Эрдэм шинжилгээ, инновацийн газар, СТХ хариуцсан Нарийн бичиг нарт хүргүүлнэ.
- ЭШИГ хэрэгжиж буй төслүүдийн тайлан дүн мэдээг нэгтгэж, төслийн гэрээний эрх үүрэг зөрчигдсөн хэрэгжилт хангалтгүй байгаа төслийг ШУТИС-ийн ЭШИХА-ны дэд зөвлөлөөр хэлэлцүүлж, шаардлагатай шийдвэрийг гаргуулна.

7.4 Санхүүжилт авсан төслийн багийн үүрэг хариуцлага, хүрэх үр дүнгийн амлалт (KPI)

- Санхүүжилт авсан төслийн баг нь батлагдсан төсөлд заасан судалгааны хүрээ, зорилго, үр дүнд хүрэх судалгаа болон судалгаатай холбоотой үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх үүрэгтэй. Төслийг төлөвлөгөөний дагуу, цаг хугацаандаа хэрэгжиж, санхүүжилтийн нөхцлийг баримтлан ажиллаж байгаад хяналттай ажиллана. Үүний тулд үйл ажиллагаа бүртгэй холбоотой зардлын хүсэлтийг хянаж батлах, баталсан санхүүжилтийн зарцуулалтыг хянах ШУТИС-ийн тогтсон дүрэм журмыг баримталж ажиллана. ШУТИС-ийн санхүүгийн хяналт нь төслийн санал болгож буй үйл ажиллагааны зардал нь зөвшөөрөгдсөн, үйл ажиллагаа нь СТХ-ийн санхүүжилтийн нөхцөлтэй нийцсэн, зорилго, зорилтынхоо хүрээнд, нөөцийг зөв ашиглаж буй ажил болохыг баталгаажуулах үйл явц юм.
- Хэдийгээр төслийн баг болон ШУТИС хянах хэрэгжүүлэх үүрэг гүйцэтгэж байгаа ч гэсэн, СТХ-ийн нарийн бичиг, төслийн ахлагч нар төслийн явц өөрчлөлтийн талаар байнга холбоотой ажиллана.
- СТХ нь төлөөлөгчөөрөө дамжуулан төслийн хэрэгжилтийн явцыг хэдийд ч төслийн байранд очин, төслийн багийнхантай уулзах эрхтэй байна, хэрвээ шаардлагатай бол техникийн зөвлөгөө өгнө. Төлөөлөгчийн төслийн явцтай танилцах бүх бололцоогоор хангаж өгнө.
- Хэрэв төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үр дүнгээрээ эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэн нийтлүүлэх бол аль болох олон улсын Эрдэм шинжилгээ, судалгааны санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлэхийг зорих. /ШУТИС-ийн ЭШИГ-аас зөвшилцсөн байх/
- Төслийн судалгааны үр дүнд хэвлэн нийтлэгдэж буй аливаа бүтээл ШУТИС нэр дээр бичигдэх бөгөөд санхүүжүүлэгчийг төслийн нэрний хамт дурьдах
- Төслийн үр дүнд оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэх /Патент, ашигтай загвар, зохиогийн эрх, бүтээгдэхүүний загвар/ бол бүтээлийн төрлөөс үл хамаарч тухайн бүтээлийн оюуны өмчийн эрх эзэмшигч нь ШУТИС, Оюу толгой, Рио Тинто нар байна.

7.5 Төслийн үр дүнг хэлэлцэж, хүлээлгэн өгөх

- Төслийн эцсийн тайлан: Төслийн эцсийн тайлан нь нийт төслийн хугацааг хамруулахгүйгээр зөвхөн тайлангийн хугацаанд хийсэн үйл ажиллагааг тайлагнана. Эцсийн тайлан учраас төслөөс хүлээх үр дүн хэрхэн биелсэн талаар тайлагнана, мөн ямар үр нөлөө үзүүлсэн талаар оруулна. Төслийн ахлах төслийн судалгаа, үйл ажиллагаа бүрэн дуусч, цаашаа аливаа нэг дутуу ажил үлдээгүй, төлбөр тооцоо дууссан гэдгийг мэдэгдэж, эцсийн тайланг явуулна.
- Төслийн үр дүнгийн хэлэлцүүлгийг тухайн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөл болон ЭШИХА-ны дэд зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулах бөгөөд дүгнэлтийг үндэслэн ЭШИХ дэд захирлын гарын үсэгтэй төсөл хүлээлгэн өгөх албан бичгийг Оюу толгой ХХК-д болон удирдах хороонд хүргүүлнэ.
- Төсөл хэрэгжүүлсэний үр дүнд бий болсон үндсэн хөрөнгө, техник тоног төхөөрөмжийг ШУТИС эзэмшинэ. Хэрэв санхүүжүүлэгч байгууллага эзэмших санал гаргавал харилцан тохиролцож хэрхэн эзэмших талаар гэрээнд тусгана.
- Төслийн удирдагч гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө төслийн үр дүн, санхүүгийн гүйцэтгэлийн тайланг захиалагчид актаар хүлээлгэж өгнө. Тус актыг нэг хувийг ЭШИГ-д ирүүлснээр эцсийн тайланг хүлээлгэн өгөх үйл явц дуусгавар болно.
- Дуусгавар болсон төслийн үр дүн, мэдээллийг СТХ-ийн нарийн бичиг хариуцан ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн санд оруулж, цахим архив үүсгэнэ.
- Олон нийтэд зориулсан төслийн үр дүнгийн тайлан: Энэ тайлан нь төслийн хураангуй тайлан бөгөөд мэргэжлийн бус хүмүүст ойлгогдохоор энгийн үг хэллэгээр төслийн зорилго, үр дүн, ач холбогдол, үр нөлөөг тайлагнана. Төслийн судалгааны үр дүнд гарсан хэвлэгдсэн бүтээл, дата, сургалтын материалыг СТХ-өөс вэб сайтад тавина. Тайланд нууцлалтай мэдээлэл, патент, үр дүн нь баталгаажаагүй судалгааны дата, болон хувь хүний мэдээллийг оруулахгүй. Олон нийтэд зориулсан тайланг төслийн эцсийн хугацаанаас хойш 60 хоногийн дотор илгээнэ.

7.6 Төслийн хаалт

- Төслийн хаалт нь СТХ-ийн зүгээс уг судалгааны төслийн үр дүнг хүлээн авч, бүх төлбөр тооцоо дууссаныг илэрхийлнэ. Төгсгөлийн зарцуулалт нь тухайн үед бичигдсэн зардал дээр үндэслэгдэнэ.

- Мэдээллийн хадгалалт: Санхүүгийн баримт, төслийн бичиг баримт, статистик мэдээ, болон СТХ-тэй холбоотой бүх мэдээллийг төсөл дууссан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хадгална.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Төслүүдийн хэрэгжилт, зохион байгуулалт, хяналтыг ШУТИС-ийн ЭШИГ, СТХ-ийн нарийн бичиг, төслийн удирдах хороо хариуцан явуулна.
- 8.2 Энэхүү удирдамжийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч бүтцийн нэгжийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, ахлах нягтлан бодогч, төслийн удирдагч, буруутай этгээдэд их сургуулийн холбогдох дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 8.3 Энэхүү удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг талуудын саналыг үндэслэн төслийн Удирдах хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.
- 8.4 Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн зөрчил, маргааныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шүүхээр шийдвэрлүүлнэ.

---o0o---